

**МОНГОЛ УЛСЫН  
ТҮҮХ**

**2008**

ХУВИЛБАР D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Монголын нууц товчоо бол Дундад зууны үед нэг ч үндэстэн, Монголын адилаар түүхч нарын анхаарлыг татсангүй гэж хэлж болох бөгөөд нууц товчооны адилаар жинхэнэ амьдралыг тодорхой дүрслэн үзүүлсэн дурсгалт бичгийг нэг ч нүүдэлчин үндэстэн үлдээсэнгүй” гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)  
А. В.Я.Владимирцов                      В. А.И.Герцен                      С. Л.Л.Окладников  
D. Л.Н.Гумилев                              Е. В.В.Волков
2. Чулуун зэвсгийн мезолитийн үеийг Монголоор юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсэг                      В. Шинэ чулуун зэвсэг                      С. Дунд чулуун зэвсэг  
D. Хүрэл    Е. Төмөр
3. Чулуун зэвсгийн үеийг дотор нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)  
А. Бүдүүлэг, завсрын, боловсронгуй чулуун зэвсэг  
В. Болхи, бүдүүлэг, хөгжингүй чулуун зэвсэг  
С. Хуучин, дунд, шинэ чулуун зэвсэг  
D. Бүдүүлэг, завсрын, шинэ чулуун зэвсэг  
Е. Хуучин, бүдүүлэг, хөгжингүй чулуун зэвсэг
4. Шинэ чулуун зэвсгийн үед хүн суурьшмал амьдралд шилжиж эхэлснийг хаанаас олдсон дурсгалуудаас мэдэж болох вэ? (2 оноо)  
А. Өвөрхангайн Арц Богд, Дундговийн Ёроол говь  
В. Ховдын Манханы Хойд цэнхэр, Өвөрхангайн Хархорин  
С. Сүхбаатарын Онгон, Мөнххаан сум  
D. Баянхонгорын Баянлиг, Хэнтийн Рашаант  
Е. Өвөрхангайн Богд, Ховдын Чандмань
5. Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн голын дурсгал аль үед хамаарах вэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсэг                      В. Шинэ чулуун зэвсэг                      С. Хүрэл зэвсэг  
D. Төмөр зэвсэг                                  Е. Хүннү
6. Дунд чулуун зэвсгийн үед гарсан онцлог зүйлээс харгалзахыг сонгоно уу. (2 оноо)  
А. Мал аж ахуй, ан агнуур, газар тариалан эрхэлж эхэлсэн  
В. Иртэй зэвсэг, зүймэл зэвсэг, ялтсан зэвээр зэвсэг хийдэг болсон  
С. Нум, сум хэрэглэх болсон  
D. Бүгд зөв
7. Хүннүгийн үеийн томоохон дурсгалуудын нэг нь Ноён уулын дурсгал мөн. Аль аймгийн нутагт байдаг вэ? (2 оноо)  
А. Ховд    В. Баянхонгор                                      С. Сэлэнгэ  
D. Төв    Е. Дундговь
8. Увс аймгийн Чандмань уулын дурсгал хэдий үед хамаарагдах вэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсэг                      В. Шинэ чулуун зэвсэг                      С. Хүрэл зэвсэг  
D. Хүрэл, Төмөр зэвсгийн түрүү                                      Е. Хүннү
9. Монгол болон Евроазийн нутагт өргөн тархсан буган чулуун хөшөөнүүдэд бугыг хэрхэн дүрсэлсэн байдаг вэ? (2 оноо)  
А. Зөвхөн бодит байдлаар                      В. Зөвхөн загварчилж                      С. Бодит болон загварчилж  
D. Улаан зосоор зурж                              Е. Бэхээр зурж
10. Монгол нутагт өргөн тархсан хүрлийн үеийн дурсгалд аль нь хамаарах вэ? (2 оноо)  
А. Гилбэр, хянгар                                  В. Хусуур залтас                                  С. Чулуун зэв  
D. Тариа цайруулдаг самбар                      Е. Хиргисүүр
11. Руни бичгийн дурсгал /Тоньюкук, Культегин/ болох гэрэлт хөшөөний бичээсийн гол агуулга нь юуны тухай өгүүлсэн бэ? (2 оноо)  
А. Хувь хүний намтар                                  В. Түрэгийн түүх                                  С. Дайн байлдааны тухай  
D. Эв найрамдал                                      Е. А ба С
12. Уйгур улсын анхны хаан хэн байсан бэ? (2 оноо)  
А. Культегин    В. Пэйло    С. Моюнчур  
D. Билэг    Е. Могилян
13. Монголд бурханы шашин хүчтэй дэлгэрсэн нь ямар цаг үед хамаарах вэ?  
А. Их Монгол улсын үед                                  В. Улс төрийн бутралын үед  
С. Юань гүрний үед                                      D. Хүннү

14. XI-XII зууны үед язгуурын Монгол аймгууд Нирун ба Дарлигин гэсэн хоёр бүлэгт хуваагддаг байжээ. Дарлигин аймгууд гэж ямар овог аймгийнханийг нэрлэдэг вэ?  
 А. Добу мэргэний бэлэвсэн хатан Алунгоогийн гурван хөвгүүдийн удмаас үүсэлтэй овог аймаг  
 В. “Эргүнэ гүн” очсон Нукуз, Хиян хоёр овгоос үржин олон болсон Эргүнэ гүний Монголчууд  
 С. Хамаг Монголоос бусад ханлиг аймгууд  
 D. Хамаг Монголын ханлигийн бүрэлдэхүүнд багтах бүх овог, аймгууд  
 E. Хабул хааны удмынхан
15. Эртний монголчууд бөөгийн шашин шүтэж ирсэн уламжлалтай билээ. Удган бөө гэж ямар хүнийг нэрлэж байсан бэ? (2 оноо)  
 А. Эрэгтэй бөө  
 В. Эмэгтэй хүн  
 С. Зан үйл хийдэг хүн  
 D. Өндөр настай хүн  
 E. А ба В
16. XIV-XVII зууны Монголын соёлын гол төлөөлөгчдөд хамааралгүй нь хэн бэ? (2 оноо)  
 А. Занабазар  
 В. Лувсанданзан  
 С. Гунгаа-Одсэр  
 D. Пагва лам  
 E. Зая бандид Намхайжамц
17. XIII зууны Монголын түүхэнд холбогдох анхны бичгийн дурсгал аль нь вэ? (2 оноо)  
 А. Хар татарын тэмдэглэл  
 В. Монголын нууц товчоо  
 С. Чингисийн чулууны бичиг  
 D. Мөнх хааны гэрэлт хөшөө  
 E. Лу.Алтан товч
18. Дор дурьдсан улсуудын аль нь “Эл улс” хэмээн нэрлэгддэг вэ? (2 оноо)  
 А. Хүннү  
 В. Сяньби  
 С. Нирун  
 D. Түрэг  
 E. Уйгур
19. Монголчууд эртнээс бичиг үсэг зохион хэрэглэж, номыг торгонд баринтаглан шүтэж ирсэн түүхтэй ард түмэн билээ. Хэн ямар бичиг үсэг болон дүрэм зохиосныг зөв тохируулна уу. (4 оноо)  
 А. Дөрвөлжин үсэг  
 1. Өндөр гэгээн Занабазар  
 В. Тод үсэг  
 2. Дамдинсүрэн  
 С. Соёмбо үсэг  
 3. Пагва лам  
 D. Кирилл  
 4. Зая бандид Намхайжамц  
 А. А3 В4 С1 D2  
 В. А4 В1 С2 D3  
 С. А4 В2 С1 D3  
 D. А4 В2 С1 D3  
 E. А1 В3 С2 D4
20. Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үйл хэрэгт хамгийн чухалд тооцогдохыг олно уу. (2 оноо)  
 А. Чингис хааны удам олон зуун жилийн турш төрийн эрх барьсан  
 В. Хархорумыг улсын нийслэл болгосон  
 С. Дэлхийн бусад оронтой худалдаа арилжааг өргөнөөр хийх болсон  
 D. Тархай бутархай Монгол олон аймаг, ханлигуудыг нэгтгэж, хүчирхэг Их Монгол улсыг байгуулсан  
 E. Хамаг Монголын хаадыг хороож байсан Зүрчидийн Алтан улсаас өшөөгөө авч чадсан
21. Чингис хааны 4 хөвгүүнийг насны дарааллаар аль нь зөв эрэмбэлсэн байна вэ? (2 оноо)  
 А. Зүчи, Өгөдэй, Цагаадай, Тулуй  
 В. Зүчи, Цагаадай, Тулуй, Өгөдэй  
 С. Цагаадай, Өгөдэй, Зүчи, Тулуй  
 D. Цагаадай, Өгөдэй, Зүчи, Тулуй  
 E. Зүчи, Цагаадай, Өгөдэй, Тулуй
22. Их Монгол улсын нэрийг өөрчилж, Юань гүрэн гэж хэдийд нэрлэх болсон бэ? (2 оноо)  
 А. 1260 он  
 В. 1264 он  
 С. 1268 он  
 D. 1272 он  
 E. 1271 он
23. Хаан ширээний төлөө Хубилай хэнтэй тэмцэлдсэн бэ? (2 оноо)  
 А. Аригбөх  
 В. Бат  
 С. Хүлэгү  
 D. Муха  
 E. Аль нь ч биш
24. Чингис хааны бага хүү Тулуйн хүү Хүлэгүгийн байгуулсан улсыг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)  
 А. Их Монгол улс  
 В. Ил хаант улс  
 С. Цагаадайн улс  
 D. Султаны улс  
 E. Алтан ордон улс
25. XVIII-XIX зууны үеийн Монголын соёлын онцлогийг харуулах зүйл бол уран барилгын дурсгалууд бөгөөд түүний нэг нь Манзуширын хийд юм. Энэ хийд аль аймгийн нутагт байдаг вэ?  
 А. Сэлэнгэ  
 В. Дундговь  
 С. Өвөрхангай  
 D. Төв  
 E. Булган
26. Хубилай хаан нийслэлээ Бээжинд яагаад шилжүүлэх болсон бэ? (2 оноо)  
 А. Багаасаа Хятад газар өсөж хүмүүжсэн  
 В. Хятад багш нарынхаа үгийг дагасан  
 С. Зам харилцаа муу байснаас болсон  
 D. Монголд эсэргүүцэл тэмцэл гаргахаас болгоомжилсон  
 E. Суурин иргэдийг ойроос захиран барьсан

27. Монголын нууц товчоонд “Цээлийн ус ширгэв. Цэгээн чулуу хагарав” хэмээсний гол утга санаа юу вэ? (2 оноо)  
А. Газар хөлдлөлт болсоныг  
В. Төвлөрсөн захиргаа алдагдаж, тарж бутарсаныг  
С. Ган гачиг тохиолдсоныг  
D. Дайн байлдаан болсоныг  
E. Өвчин тахал гарсаныг
28. Давааны арын Монголчууд хэмээх томъёолол аль хааны үед холбогдох вэ? (2 оноо)  
А. Чингис хаан  
B. Өгөдэй хаан  
C. Гүюг хаан  
D. Мөнх хаан  
E. Хубилай хаан
29. Чингис хааныг залгамжлагчдаас хэн нь Алтан ордон улсыг үндэслэн байгуулсан бэ? (2 оноо)  
А. Мөнх хаан  
B. Хүлэгү  
C. Цагаадай  
D. Зүчи  
E. Бат
30. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг хэзээнээс хэрэгжүүлж эхэлсэн бэ? (2 оноо)  
А. 1992.01.13  
B. 1992.11.26  
C. 1992.02.12  
D. 1992.06.25  
E. 1992.03.01
31. Япончууд Монголруу хэдэн онд халдан довтолсон бэ? (2 оноо)  
А. 1937 он  
B. 1938 он  
C. 1939 он  
D. 1940 он  
E. 1945 он
32. Хутагтай сэцэн хунтайжийн зохиосон “Алтан ханы цааз”-ын түвд орчуулга аль улсын музейд байдаг вэ? (2 оноо)  
А. Монгол-Үндэсний түүхийн музей  
B. Хятад-Түүхийн музей  
C. ОХУ-Эрмитаж  
D. Франц-Лувр  
E. Англи-Ливерпуль
33. Юан гүрний сүүлчийн эзэн хаан хэн байсан бэ? (2 оноо)  
А. Хүлэг  
B. Тогоонтөмөр  
C. Есөнтөмөр  
D. Ринчинбал  
E. Өлзийт
34. Чингис хааныг хүртэлх Хамаг Монголыг захирч байсан хаадад хамааралгүйг нь олно уу. (2 оноо)  
А. Хабул хаан  
B. Амбагай хаан  
C. Хотул хаан  
D. Гүр хаан  
E. Есүхэй
35. XI-XII зууны үеийн Найман аймгийн нутаглаж байсан газрыг олно уу. (2 оноо)  
А. Алтай, Хангайн нурууны зааг нутгаар  
B. Алтайн нуруунаас зүүн тийш  
C. Хангайн нуруунаас зүүн тийш  
D. Орхон голоос Эрчис мөрөн, Зайсан нуур хүртэл  
E. Хамаг Монголоос баруун тийш
36. 1992 оны Үндсэн хуулиар засгийн эрх мэдэл хэний гарт байна гэж тодорхойлсон бэ? (2 оноо)  
А. Засгийн газар  
B. Ерөнхийлөгч  
C. УИХ  
D. Ард түмэн  
E. Улс төрийн нам
37. Монгол төрийн засаглалын хэлбэрийг оршин тогтнож байсан түүхэн хугацаагаар нь дараалуулан эрэмбэлнэ үү. (3 оноо)  
1. Ардын эрхт хэмжээт цаазат төр  
2. Бүрэн эрхт бүгд найрамдах улс  
3. Хэмжээгүй эрхт хаант засаг  
А. 3 2 1  
B. 1 2 3  
C. 3 1 2  
D. 1 3 2  
E. 2 3 1
38. 1913 онд Оросын Алс дорнод сэтгүүлд “Хувийн амьдралын хувьд аглаг даяанч, байгалиас заяасан тулх ухаантай, хэнд ч уусаж худалдагдахгүй, хувийн ашиг хонжоо хайдаггүй, хүнд тэр бүр итгэдэггүй, хянуур болгоомжтой...” хэмээн үнэлэлт авсан Монголын төрийн ухаалаг, холч хараатай зүтгэлтэн хэн бэ? (2 оноо)  
А. Да лам Цэрэнчимэд  
B. Чин ван Ханддорж  
C. Богд Жибзундамба  
D. Хайсан түшмэл  
E. Түшээ гүн Чагдаржав
39. Монгол улсад хэдий үеэс олон намын системийн эрх зүйн үндэс тавигдсан бэ? (2 оноо)  
А. 1924 оны Үндсэн хууль  
B. 1940 оны Үндсэн хууль  
C. 1960 оны Үндсэн хууль  
D. 1992 оны Үндсэн хууль
40. Хөвсгөл, Архангай, Алтай, Завхан, Өвөрхангай зэрэг аймгуудад зүүнтний бодлого, ажиллагаанд дургүйцсэн ардуудын эсэргүүцэл хүчтэй өрнөсөн томоохон үйл явдал аль нь вэ? (2 оноо)  
А. Хамтрал коммун байгуулсан  
B. 1929 оны хөрөнгө хураах ажиллагаа  
C. 1932 оны зэвсэгт бослого  
D. 1937 оны хэлмэгдүүлэлт  
E. 1932 оны Шинэ эргэлтийн бодлого

41. 1920.10.02-нд Барон Унгерний захирсан “Азийн морин дивиз”-ийн 800-аад цэрэг Онон голын сав, Гилбэр харуулын нутгаар Монголын хил рүү цөмрөн орж ирсэн. Цагаан цэргийн зорилгод хамааралгүй зүйл дурдсан бол аль нь вэ? (3 оноо)
- А. Улаан цэргийн цохилтоос зугтан зайлах  
 В. Большевикуудын эсрэг түшиц газраа болгох  
 С. Монголчуудын хүч нөөцийг өөртөө татах, ашиглах  
 D. Монголчуудад тусламж дэмжлэг өгөх  
 E. Бүгд хамааралтай
42. 2008 оноос Атар газрыг эзэмших хэд дэх аян эхэлж байна вэ? (2 оноо)
- А. 1                      В. 2                      С. 3                      D. 4                      E. 5
43. Хувьсгалт нууц бүлгийн 7 гишүүн 1920 оны 8-р сард нууцаар, ээлж дараагаар ЗОУ-ын Эрхүү хотод очиж, Оросын Коммунист намын хүмүүстэй уулзан туршлага солилцсон явдал хувьсгалын цаашдын үйл хэрэг өрнөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ. Нууц бүлгэмийн гишүүд ажил үүргийн хуваарь гарган 3 хэсэг болж ажиллажээ. Тэднээс Монголруу буцаж ирэн намын үйл хэргийг үргэлжлүүлсэн нь хэн, хэн бэ? (2 оноо)
- А. Сүхбаатар, Чойбалсан                      В. Догсом, Бодоо  
 С. Лосол, Данзан, Чагдаржав                      D. Дугаржав, Чойбалсан  
 E. Данзан, Бодоо
44. Манж Чин улс Монгол улсыг эрхшээлдээ байлгах хатуу бодлого явуулж байсан. Үүний нэг нь Шинэ засгийн бодлого бөгөөд ямар чиглэлээр Монголд явуулах болсон бэ? (2 оноо)
- А. Улс төр, эдийн засаг, шашин                      В. Улс төр, эдийн засаг, соёл  
 С. Монголыг хятадчилах                      D. Эдийн засгийг хурдасгах  
 E. Шинэ соёлыг нэвтрүүлэх
45. Хамаг Монголын хан Хабулыг хэн залгамжилсан бэ?
- А. Амбагай                      В. Хотула                      С. Тэмүжин  
 D. Есүхэй                      E. Тоорил
46. Манжийн эрхшээлд байх үеийн Монголын нийгэм, улс төр, үзэл санааны гол чиглэл нь юу байсан бэ? (2 оноо)
- А. Эв нэгдлийн үзэл санаа                      В. Тусгаар тогтнолын үзэл санаа  
 С. Хөгжлийн үзэл санаа                      D. Гадаад харилцаа  
 E. Дээрх бүгд
47. Гоминданы Засгийн газар Монгол улсын тусгаар тогтнолыг хэдийд хүлээн зөвшөөрсөн бэ? (2 оноо)
- А. 1924 он                      В. 1939 он                      С. 1946 он  
 D. 1949 он                      E. 1961 он
48. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нарыг зөв харгалзуулна уу. (4 оноо)
- А. Х.Чойбалсан                      1. 1952-1974  
 В. Ю.Цэдэнбал                      2. 1974-1984  
 С. Ж.Батмөнх                      3. 1984-1990  
 D. Д.Содном                      4. 1939-1952
- А. А1 В2 С4 D3                      В. А4 В1 С2 D3                      С. А4 В2 С1 D3  
 D. А4 В2 С1 D3                      E. А1 В3 С2 D4
49. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн түүхийг зөв дараалалд оруулж оныг харгалзуулна уу. (5 оноо)
1. Өргөө                      А. 1778-1911  
 2. Их хүрээ                      В. 1639-1706  
 3. Да хүрээ                      С. 1911-1924  
 4. Нийслэл хүрээ                      D. 1706-1778  
 5. Улаанбаатар                      E. 1924
- А. 1В 2D 3А 4С 5E                      В. 1С 2D 3E 4В 5А                      С. 1В 2E 3D 4А 5С                      D. 1E 2В 3А 4D 5С
50. Эрдэм судлалын байгууллага болох шинжлэх ухааны хүрээлэн хэдийд бий болсон бэ? (2 оноо)
- А. 1921 он                      В. 1924 он                      С. 1930 он                      D. 1987 он                      E. 1961 он
51. Дэлхийн II дайны үеийн хүндрэлийг давахад эдийн засгийн гол нөөц нь юу байсан бэ? (2 оноо)
- А. Аж үйлдвэр                      В. Хөнгөн, хүнсний үйлдвэр                      С. Газар тариалан  
 D. Мал аж ахуй                      E. Ардын аж ахуйтан
52. Монголд бурханы шашныг анх дэлгэрүүлсэн гэж хэн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг вэ? (2 оноо)
- А. Өндөр гэгээн Занабазар                      В. Алтан хан                      С. Зая бандид Намхайжамц  
 D. Абтай сайн хан                      E. Түмэн засагт хан
53. 1929-1932 оны хооронд “Хөрөнгө хураах комисс” байгуулж, орон даяар феодал агсадын хөрөнгө хураах ажиллагаа орон даяар эхэлжээ. Уг комисс хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байсан бэ? (2 оноо)
- А. 4                      В. 6                      С. 8                      D. 12                      E. 14

## Боловсролын Үнэлгээний Төв

54. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөр Монгол, Мавритан хоёр улсыг НҮБ-ын гишүүнээр нэгэн зэрэг элсүүлэх тухай хэлэлцэхэд БНМАУ-ыг элсүүлэхийг зөвлөмж болгосон тогтоолын төслийг 9 улс дэмжиж, 1 улс түтгэлзсэн бөгөөд Чан Кай Шигийн төлөөлөгч санал хураалтанд оролцоогүй юм. Хэдэн онд Монгол улс НҮБ-ын гишүүн улс болсон бэ? (2 оноо)  
А. 1947 он В. 1949 он С. 1956 он D. 1961 он E. 1963 он
55. Захиран тушаах хүнд суртлын тогтолцоо хэдий үеэс бэхжсэн бэ? (2 оноо)  
А. 1960-аад оноос В. 1940-өөд оноос С. 1970-аад оноос  
D. 1950-иад оноос E. 1980-аад оноос
56. Нацизмын үзэл гэж юуг хэлэх вэ? (2 оноо)  
А. Зэвсэглэлээр далайлгах бодлого В. Нийгмийн эсрэг, тэсрэг ангийн үзэл  
С. Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл D. Их гүрэн өөрийн бодлогыг бусдад тулгах бодлого  
E. Тухайн улсын гадаад бодлогын үзэл номлол
57. Монгол улс гадаад бодлогын үндсэн хэдэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа вэ? (2 оноо)  
А. 4 В. 6 С. 7 D. 8 E. 10
58. 1992 оны Үндсэн хуулиар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хэрхэн тодорхойлсон бэ? (3 оноо)  
А. Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх  
В. Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх  
С. Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс  
D. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх  
E. Дээрх бүгд зөв

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)  
А. Тайж 1. Боржигон овгийн бус язгууртны толгойлогч  
В. Хохь тайж 2. Албат хамжлагагүй, хөрөнгө хогшил багатай  
С. Тайш 3. Чингис хааны удмын үр ач  
D. Хунтайж 4. Хаан ширээг залгамжлах хүү
- 2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)  
А. Монголын Ардчилсан Холбоо байгуулагдав 1. 1990.07.29  
В. Монголд ардчилсан сонгууль болов 2. 1990.03.07  
С. Дугуй ширээний уулзалт хийгдэв 3. 1991.04.14  
D. Банкны тухай хууль гарав 4. 1989.12.10  
E. Өлсгөлөн зарлав 5. 1990.03.09

### ХУВИЛБАР F

#### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Хэтээсээ том улс үндэстэн бага буурай улс үндэстнийг түрэмгийлэн эзэлж, удирдагчийг барьж хорьдог. Яг тийм маягаар ЗХУ Монгол улсад хандаж байна. Түүний тод жишээ нь миний бие” хэмээх эх орончийн зоримог үгийг хэн хэлсэн бэ? (2 оноо)  
А. А.Амар В. Б.Цэрэндорж С. Д.Бодоо  
D. Д.Сүхбаатар E. Х.Чойбалсан
2. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дах Оцон мааньтын дурсгал аль үеийн дурсгалд хамаарах вэ? (2 оноо)  
А. Хуучин чулуун зэвсэг В. Дунд чулуун зэвсэг С. Шинэ чулуун зэвсэг  
D. Хүрэл зэвсэг E. Төмөр зэвсэг
3. Монгол нутгаас олдсон шинэ чулуун зэвсгийн үеийн бууц, суурингуудаас хамгийн томоохон нь хаанаас олдсон бэ? (2 оноо)  
А. Ховдын Манхан сум В. Дорноговь аймгийн Тамсагбулаг  
С. Баянхонгор аймгийн Баянлиг D. Дорнод аймгийн Халх гол
4. Доорх өгөгдлүүдээс шинэ чулуун зэвсгийн дурсгалд аль нь хамааралтайг олно уу. (2 оноо)  
А. Рашаан хад, Орхон голын сав, Мойлтын ам, Хэрээ уул  
В. Дорнодын Овоот уул, Дорноговь аймгийн Дулааны говь  
С. Баянхонгор аймгийн Баянлиг, Өвөрхангай аймгийн Богд  
D. Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгойн хадны зураг  
E. Бүгд хамааралгүй

5. Өмнөговь аймгийн Булган сумын Төгрөгийн Ширээнээс олдсон гилбэр мэс аль үеийн дурсгал вэ? (2 оноо)  
 А. Хуучин чулуун зэвсгийн доод шат  
 В. Хуучин чулуун зэвсгийн дунд шат  
 С. Хуучин чулуун зэвсгийн дээд шат  
 D. Дунд чулуун зэвсэг  
 E. Шинэ чулуун зэвсэг
6. Монгол нутаг дах доод палеолитийн үеийн онцлог шинжийг тодорхойлно уу. (2 оноо)  
 А. Хүн сүргээр амьдардаг  
 В. Мод, навчаар хийсэн хувцастай байгаад амьтдын арьсан хувцас өмсөх болсон  
 С. Чулуун зэвсгийг холтчих, хэлтлэх, хугалах аргаар хийнэ  
 D. Бүгд зөв  
 E. Бүгд хамааралгүй
7. Хиргисүүр, буган чулуун хөшөө, дөрвөлжин булш зэрэг дурсгалууд нь хэдий үеийн дурсгалд хамаарагдах вэ? (2 оноо)  
 А. Хуучин чулуун зэвсэг  
 В. Шинэ чулуун зэвсэг  
 С. Хүрэл зэвсэг  
 D. Төмөр зэвсэг  
 E. Хүннү
8. Дараах өгөгдлүүдийн аль нь Дарлигин аймгийн үүслийг тодорхойлох вэ? (2 оноо)  
 А. Нирун, Хиад аймгуудаас салбарласан  
 В. Добу мэргэний бэлэвсэн гэргий Алунгоогоос гарсан Буха хагаги, Бухату салжи, Бодончар мунхагаас үүссэн  
 С. Добу мэргэний амьд ахуйд гарсан Бэлгүнүтэй, Бүгүнүтэйн үрс болон бусдаас үүссэн  
 D. Бодончарын авсан Жарчиуд Аданханы үрс  
 E. Бүгд зөв
9. Татарууд Охинбархагийг гэнэдүүлэн баривчилж Алтан улсад хүргүүлэн модон илжгэнд хадаж амийг нь хөнөөлгүүлжээ. Тэрбээр Хамаг Монголын хааны хэний нь хүү байсан бэ? (2 оноо)  
 А. Хабул хаан  
 В. Амбагай хаан  
 С. Хотула хаан  
 D. Гүр хаан  
 E. Есүхэй
10. Төрийн зүтгэлтэн хүн өөртөө шүүмжлэлтэй хандаж, эерэг, сөрөг үйлдлээ үнэлж, цэгнэх ёстойг анх сэдэж өөрийн үйл ажиллагаагаараа нотолсон Монголын хаан хэн бэ? (2 оноо)  
 А. Чингис  
 В. Өгөдэй  
 С. Гүюг  
 D. Мөнх  
 E. Хубилай
11. Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үйл хэрэгт хамгийн чухал тооцогдохыг олно уу. (3 оноо)  
 А. Чингис хааны удам олон зуун жилийн турш төрийн эрх барьсан  
 В. Хархорумыг улсын нийслэл болгосон  
 С. Дэлхийн бусад оронтой худалдаа арилжааг өргөнөөр хийх болсон  
 D. Тархай бутархай Монгол олон аймаг, ханлигуудыг нэгтгэж, хүчирхэг Их Монгол улсыг байгуулсан  
 E. Хамаг Монголын хаадыг хороож байсан Зүрчидийн Алтан улсаас өшөөгөө авч чадсан
12. 1918 оны байдлаар хамгийн цөөн хүн амтай байсан аймгийг нэрлэнэ үү? (2 оноо)  
 А. Цэцэн хан  
 В. Сайн ноён хан  
 С. Түшээт хан  
 D. Засагт хан  
 E. Их шавь
13. Монголын ард түмний 1755-1758 оны тэмцлийн гол үр дүн нь юунд орших вэ? (2 оноо)  
 А. Манжийн ноёрхолыг түлхэн унагасан  
 В. Биеэ даасан Монгол улсыг байгуулсан  
 С. Нийт монголчуудын Манжид эзлэгдэх аюулыг зогсоосон  
 D. Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийг тодорхой туршлагаар баяжуулсан
14. Саган сэцэний “Эрдэнийн эрхи”-д өгүүлсэнээр “Дөчин дөрвөн хоёрыг эзэлж хаан суув” гэдгийг хэн хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)  
 А. Галдан бошигт  
 В. Лигдэн хаан  
 С. Эсэн тайш  
 D. Цогт тайж  
 E. Даян хаан
15. Халх Монгол Манж Чин Улсад дагаар орох ёслол хэдэн онд, хаана болсон бэ? (2 оноо)  
 А. Заг байдрагийн Хүрэн бэлчир-1686  
 В. Ар элстэй-1688  
 С. Долнуур-1691  
 D. Ширээ цагаан нуур-1698  
 E. Улаан бураа-1640
16. Монгол Оросын хилийн заагийг 1727 онд тогтоов. Ямар гэрээгээр зохицуулсан бэ? (2 оноо)  
 А. Хиагтын гэрээ  
 В. Буурын гэрээ  
 С. Гурван улсын гэрээ  
 D. Нэрчүгийн гэрээ  
 E. Манжийн хааны зарлигаар
17. Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн нутагт алтны уурхайг ашиглах “Монголор” гэдэг гадаад улсуудын хамтарсан, хувь нийлүүлсэн нийгэмлэг хэзээ байгуулагдсан бэ? (2 оноо)  
 А. 1873 он  
 В. 1885 он  
 С. 1891 он  
 D. 1900 он  
 E. 1903 он

18. Өндөр гэгээн Занабазар нь шашин, соёлын нэрт зүтгэлтэн төдийгүй Монголд цутгуурын урлагийг үндэслэгч юм. Түүний хийсэн бүтээл аль нь вэ? (2 оноо)  
А. Намсрай В. Гомбо С. Ямандаг D. Майдар E. Жамсран
19. Манжийн хаан 1907 онд Монгол нутгийг хагалбарлан тариа тарих зарлиг буулгаснаас хойш дөрвөн жилийн дотор Ар Монголд байгаа хятад иргэдийн тоо 100 мянгад хүрчээ. Энэ нь юунд чиглэгдэж байсан бэ? (2 оноо)  
А. Монголын эдийн засгийг дэмжих В. Газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх  
С. Монголчуудыг хятадчилах D. Монголчуудыг тариалангийн ажилд сургах
20. Богд хаант Монгол улсын төрийн үйл ажиллагаа хэдэн яамаар дамжин хэрэгждэг байсан бэ? (2 оноо)  
А. 9 В. 8 С. 6 D. 5 E. 7
21. Аль нь XIII зууны үеийн түүхэн сурвалж бичигт хамаарахгүй вэ? (2 оноо)  
А. Юан улсын судар В. Чингис хааны эш хөрөг С. Цогтын чулууны бичиг  
D. Эрдэнийн эрхи E. Дээрх бүгд хамаарна
22. 1921 онд байгуулагдсан Шинжлэх ухааны байгууллагыг юу гэж нэрлэж байв? (2 оноо)  
А. Шинжлэх ухааны хүрээлэн В. Судар номын хүрээлэн  
С. Судар бичгийн хүрээлэн D. Эрдэм дэлгэрүүлэх хүрээлэн  
E. Эрдэм бичгийн хүрээлэн
23. Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн үеийг зөв дараалалд оруулна уу. (3 оноо)  
А. Да хүрээ, Их хүрээ, Нийслэл хүрээ, Өргөө В. Их хүрээ, Өргөө, Да хүрээ, Нийслэл хүрээ  
С. Нийслэл хүрээ, Өргөө, Их хүрээ, Да хүрээ D. Өргөө, Их хүрээ, Да хүрээ, Нийслэл хүрээ  
E. Өргөө, Да хүрээ, Их хүрээ, Нийслэл хүрээ
24. Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд энгийн худалдаа хөгжүүлэх талаар доорх зүйлүүдээс алийг нь хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)  
А. 1932 онд нийгмийн гарал, хөрөнгө чинээний байдлыг харгалзахгүйгээр хувийн худалдаа хийх, худалдааны пүүс, нөхөрлөл байгуулахыг зөвшөөрсөн.  
В. Бөөний болон жижиглэнгийн үнээр бараа авах, банкнаас зээл авах, эрх олгосон.  
С. Хувийн худалдаачдад улсын бүх экспорт, импорт хийх эрх өгсөн.  
D. Бүгд зөв  
E. А ба В
25. Эртний монголчууд бөөгийн шашин шүтэж ирсэн уламжлалтай. Зайран гэж ямар хүнийг нэрлэж байсан бэ? (2 оноо)  
А. Эрэгтэй В. Эмэгтэй бөө С. Зан үйл хийдэг хүн  
D. Өндөр настай бөө E. А ба В
26. Хубилай хаан өмнөд Сүн улсыг хэдэн онд өөрийн эрхшээлдээ оруулсан бэ? (2 оноо)  
А. 1268 он В. 1275 он С. 1270 он  
D. 1279 он E. 1281 он
27. Галдан бошигт Халх Монголыг довтолсон шалтгааныг олно уу. (2 оноо)  
А. Халх доторх зөрчлийг дарах  
В. Халх-Ойрадыг нэгтгэн Манж Чин улсын эсрэг тэмцэх  
С. Газар нутгаа өргөтгөн, Халх Монголыг эзлэх  
D. Халх Монголыг эрхшээлдээ оруулж, хаан ширээнд суух  
E. Манж Чин улстай найрамдалын гэрээ байгуулах
28. Монголын санхүү, төсвийг эмхлэн цэгцтэй болгоход туслуулах зорилгоор Оросын Сангийн яамны түшмэл С.А.Козинг хэдэн оноос Монголд ажиллуулахаар болсон бэ? (2 оноо)  
А. 1912 он В. 1913 он С. 1914 он  
D. 1915 он E. 1916 он
29. Хөвсгөл, Архангай, Алтай, Завхан, Өвөрхангай зэрэг аймгуудад зүүнтний бодлого, ажиллагаанд дургүйцсэн ардуудын эсэргүүцэл хүчтэй өрнөсөн томоохон үйл явдалд дүгнэлт өгнө үү. (2 оноо)  
А. Хамтрал коммун байгуулсан В. 1929 оны хөрөнгө хураах ажиллагаа  
С. 1932 оны зэвсэгт бослого D. 1937 оны хэлмэгдүүлэлт  
E. 1932 оны Шинэ эргэлтийн бодлого
30. Монгол улс тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал хураалтыг хэдэн оны 10 дугаар сарын 20-ны өдөр явуулсан бэ? (2 оноо)  
А. 1945 он В. 1946 он С. 1949 он  
D. 1952 он E. 1961 он
31. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улсаас тогтоосон бараа, үйлчилгээний үнийг чөлөөлөх явдал ихээхэн чухал зүйл байлаа. Үнэ чөлөөлөх зоримог алхамыг анх хэний удирдсан Засгийн Газар хийсэн бэ? (2 оноо)  
А. П.Жасрай В. Д.Бямбасүрэн С. М.Энхсайхан  
D. Ц.Элбэгдорж E. Р.Амаржаргал



32. Аливаа ажилд нягт нямбай ханддаг учир “Хичээнгүй сайд” хэмээн алдаршсан Монголын төрийн зүтгэлтэнийг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. А.Амар В. Б.Цэрэндорж  
 С. Д.Бодоо D. Жалханз хутагт Дамдинбазар  
 Е. Х.Чойбалсан
33. 1926-1927 онд орон нутагт ажиллаж байсан засгийн газрын төлөөний түшмэдийг татан буулгасан. Юуны учир ийм арга хэмжээг авсан бэ? (3 оноо)  
 А. Ардын хувьсгал бүрэн ялж, хувьсгалын зорилго хангагдсан  
 В. Орон нутагт засгийн газрын бүрэн хяналт тогтсон  
 С. Хошууг засаг ноён үе улиран залгамжлахаа больсон  
 D. Богд хаан нас барсан тул орон нутаг дах шавийн захиргаа унасан
34. Сангийн яамны дэргэд мал эмнэлгийн хэлтэсийг хэдэн онд байгуулсан бэ? (2 оноо)  
 А. 1921 он В. 1922 он С. 1923 он  
 D. 1924 он E. 1925 он
35. Зүүнтний шашны талаар явуулсан бодлогыг олно уу. (2 оноо)  
 А. Хутагт хувилгаадын хойд дүр тодруулахыг хориглосон  
 В. 18 нас хүрээгүй хөвгүүдийг лам болгон, сүм хийдэд суухыг хязгаарласан  
 С. 19-45 насны лам нарт, цэргийн татвар ноогдуулах болсон  
 D. Хийдийн малыг ардуудад шилжүүлсэн  
 E. Бүгд зөв
36. Баруунтан гэгдэгсдийн явуулсан бодлогыг Коминтернээс буруутгасан ба түүнд үл тохирох өгөгдлийг олно уу. (3 оноо)  
 А. Шашныг дотнолон үзэж ариунаар мандуулах гэсэн  
 В. Хөрөнгөтөн этгээдийг төрүүлэхийн тулд баяжихыг дэмжсэн  
 С. Монгол улсыг ЗХУ-аас, МАХН-ыг Коминтернээс хөндийрүүлэх гэсэн  
 D. Нас барсан Хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулахгүй гэсэн
37. Зөвхөн 2 бодын хөрөнгөтэй өрхийг татвараас чөлөөлөх заалт бүхий улсын нэгдсэн албан татварын хуулийг хэзээ баталсан бэ? (2 оноо)  
 А. 1923 он В. 1924 он С. 1925 он  
 D. 1926 он E. 1928 он
38. Дотоод явдлын яамны анхны сайд хэн байсан бэ? (2 оноо)  
 А. С.Гиваапэл В. Н.Хаянхярваа С. Х.Чойбалсан  
 D. З.Шижээ E. Б.Лосол
39. Коминтерн Монголын хэрэгт оролцох болсоноор дараах зүйлийн аль нь хэрэгжих бололцоотой болсон бэ? (2 оноо)  
 А. Иргэдийн эрх ашиг, сонирхолыг дээдлэх явдлыг орхигдуулж, зөвхөн ядуу, доод хэсгийн эрх ашиг ноёрхох  
 В. Өмчийн олон хэлбэр бүхий эдийн засгийн харилцаанаас хувийн өмчийг үгүйсгэсэн эдийн засгийн харилцааг бий болгох  
 С. Үндэсний ардчилсан зарчмаас ухарч, большевик үзлийг дээдэлсэн засаглалд шилжих  
 D. А ба С  
 E. Бүгд зөв
40. 1924, 1940, 1960, 1992 онуудыг адилтгах хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)  
 А. Тусгаар тогтнолоо зарласан В. Бүгд найрамдах засаглал тогтсон  
 С. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн D. Үндсэн хууль баталсан  
 E. Эрх зүйт, ардчилсан төр бий болсон
41. Дараах сүм, хийдүүдээс аль нь Өвөрхангай аймгийн нутагт оршдог вэ? (2 оноо)  
 А. Бэрээвэн хийд В. Манзуширын хийд  
 С. Хамрын хийд D. Амарбаясгалант хийд  
 E. Төвхөн хийд
42. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд найрамдал ба харилцан туслалцах гэрээ, эдийн засаг соёлын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг хэзээ байгуулсан бэ?  
 А. 1946 он В. 1953 он С. 1974 он  
 D. 1936 он E. Бүгд буруу
43. Ногоон дарь эх бурханыг хэн урласан бэ? (2 оноо)  
 А. Д.Равжаа В. Занабазар С. Чойжи-Одсэр  
 D. Намхайжамц E. Ишбалбар

44. БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1933.12.01-ны хуралдаанаар “Улсыг батлан хамгаалах комисс”-ыг байгуулжээ. Байгуулах болсон шалтгааныг тодорхойлно уу. (2 оноо)  
А. Манжго улстай 700 км газраар хиллэх болсон  
В. Улсын төсвийн хуримтлал их болсон тул батлан хамгаалахад зарцуулах болсон  
С. Квантуны армийн үйл ажиллагаа идэвхижсэн  
D. А ба С  
E. Бүгд хамааралгүй
45. Манжийн хаан Монголчуудыг эрхшээлдээ захиран барьж байх, Монголд бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор хэдэн онд ямар хууль гаргаж монголчуудыг чандлан захирах бодлогыг хуульчилсан бэ? (2 оноо)  
А. Халх журам, 1640  
В. Монгол цаазын бичиг, 1691  
С. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын яамны хууль зүйлийн бичиг, 1798  
D. Монголын захирах хууль, 1709  
E. Бүгд буруу
46. Гоминданы Засгийн газар Монгол улсын тусгаар тогтнолыг хэдийд хүлээн зөвшөөрсөн бэ? (2 оноо)  
А. 1924 он В. 1939 он С. 1946 он D. 1949 он E. 1961 он
47. Хэдэн оны үндсэн хуулиар Хүмүүнлэг иргэний ардчилсан иргэний нийгэм байгуулах эрхэм зорилгыг тунхагласан бэ? (2 оноо)  
А. 1990 он В. 1992 он С. 1994 он D. 1996 он
48. 1628-1629 онд эртний Энэтхэгийн хөлгөн судрын чуулбар 108 боть Ганжуурыг монгол хэлнээ хэн хөрвүүлсэн бэ? (2 оноо)  
А. Цогт хун тайж В. Өндөр гэгээн Занабазар С. Зая бандид Намхайжамц  
D. Гунгаа- Одсэр E. Аюуш гүүш
49. Монгол улсын төрийн далбаа ямар өнгөөр хосолсон байдаг вэ? (2 оноо)  
А. Улаан хөх улаан В. Хөх улаан хөх С. Улаан хөх шар  
D. Хөх улаан шар E. Улаан шар хөх
50. Их хуралдайгаар санал зөрж хаан өргөмжлөх боломжгүй үед төрийн хэргийг түр хугацаагаар удирдан явуулах хязгаарлагдмал эрх өгөхийг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)  
А. Төр сахих В. Төр журамлах С. Төр эмхлэх  
D. Төр хамааруулах E. Төр эрхэмлэх
51. Монгол улсын Дээд, доод хурлаар улс орны хэмжээний олон улсын асуудлыг хэлэлцэж засгийн газраар эцсийн шийдвэр гаргуулдаг байжээ. Улсын Дээд, доод хурал хэдэн онд байгуулагдсан бэ? (2 оноо)  
А. 1911 он В. 1912 он С. 1913 он D. 1914 он E. 1915 он
52. Хаана хуралдсан холбоотнуудын тэргүүн нарын бага хурал дээр “Ар Монголын статус кво”-г хүлээн зөвшөөрөх тухай тохиролцоонд хүрсэн бэ? (2 оноо)  
А. Хиагт В. Подстам С. Тегеран  
D. Ялта E. Москва
53. Дэлхийн II дайны үеийн хүндрэлийг давахад эдийн засгийн гол нөөц нь юу байсан бэ? (2 оноо)  
А. Аж үйлдвэр В. Хөнгөн, хүнсний үйлдвэр С. Газар тариалан  
D. Мал аж ахуй E. Ардын аж ахуйтан
54. Үндэсний дээд боловсролтой боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор Монгол Улсын Их Сургуулийг хэзээ байгуулсан бэ? (2 оноо)  
А. 1942 он В. 1944 он С. 1946 он D. 1947 он E. 1948 он
55. 1992 оны Үндсэн хуулиар төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хэрхэн тодорхойлсон бэ? (3 оноо)  
А. Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх  
В. Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх  
С. Монгол улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс  
D. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх  
E. Дээрх бүгд зөв
56. Монгол улсын ерөнхий сайд П.Жасрай хэдэн онд ерөнхий сайд байсан бэ? (2 оноо)  
А. 1990-1992 он В. 1992- 1996 он С. 1996-2000 он  
D. 2000- 2004 он E. Сайд байгаагүй
57. Төрийн тамга нь дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичигтэй байх ба түүний бариул нь ямар амьтны дүрстэй вэ? (2 оноо)  
А. Бар В. Морь С. Арслан  
D. Шонхор E. Хангарьд
58. Монгол улсын Ерөнхий сайд С.Баярын Засгийн газрын хэрэгжүүлж буй атрын аян хэд дэх аян бэ? (2 оноо)  
А. 1 В. 2 С. 3 D. 4 E. 5

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нарыг зөв харгалзуулна уу. (5 оноо)
- |                 |              |
|-----------------|--------------|
| А. Х.Чойсамба   | 1. 1952-1974 |
| В. Ю.Цэдэнбал   | 2. 1974-1984 |
| С. Ж.Батмөнх    | 3. 1984-1990 |
| Д. Д.Содном     | 4. 1939-1952 |
| Е. Д.Бямбасүрэн | 5. 1990-1992 |
- 2.2. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)
- |              |  |
|--------------|--|
| А. Тайж      | 1. Боржигон овгийн бус язгууртны толгойлогч                      |
| В. Хохь тайж | 2. Хаан ширээг залгамжлах хүүг                                   |
| С. Залан     | 3. Албат хамжлагагүй, хөрөнгө хогшил багатай                     |
| Д. Хунтайж   | 4. Цэргийн хэргийг голчлон эрхлэнэ. Хошууны дөрвөн түшмэлийн нэг |
| Е. Тайш      | 5. Чингис хааны удмын үр ачийг                                   |

### ХУВИЛБАР G

#### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. 1990 оны Ардчилсан хувьсгал тайван замаар зорилтоо хэрэгжүүлсэн билээ. Энэ үед “Хүч хэрэглэж хэрхэвч үл болно” гэж хэлж байсан төрийн зүтгэлтэнг нэрлэнэ үү (2 оноо)
- |                |              |              |
|----------------|--------------|--------------|
| А. Н.Багабанди | В. С.Зориг   | С. П.Очирбат |
| Д. Д.Содном    | Е. Ж.Батмөнх |              |
2. Эртний хүмүүсийн багаж зэвсэг, эдлэл чимэглэл, гал голомтын үлдэгдэл газрын хөрсний тодорхой давхаргад хадгалагдан үлдсэн байдаг. Эртний хүний амьдралын ул мөр бүхий тэр давхаргыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
- |                   |                    |                       |
|-------------------|--------------------|-----------------------|
| А. Эдийн давхарга | В. Соёлын давхарга | С. Геологийн давхарга |
| Д. А ба В         | Е. В ба С          |                       |
3. Хоёр хөл дээрээ явагч, хоёр гар нь хөдөлмөрийн эрхтэн болсон босоо явагч хүн (Homo erectus)-ийн үндсэн шинжийг тодорхойлно уу. (2 оноо)
- А.Тархины багтаамж 1300-1600 см<sup>3</sup>  
 В. Чулууг цохиж хагалах, сэтлэх аргаар хугадас, хагадас, таргил, хянгар, шовх үлдэцүүд бэлтгэн багаж болгон ашигладаг  
 С. Цохих, цавчих, огтлох, зүсэх аргаар ан агнаж амьдардаг.  
 Д. В ба С  
 Е. Бүгд хамааралгүй
4. Эртний хүмүүсийн амьдралд нум сум хэрэглэх болсон үе чулуун зэвсгийн аль үед хамаарах вэ? (2 оноо)
- |                         |                       |                 |
|-------------------------|-----------------------|-----------------|
| А. Хуучин чулуун зэвсэг | В. Шинэ чулуун зэвсэг | С. Хүрэл зэвсэг |
| Д. Төмөр зэвсэг         | Е. Дунд чулуун зэвсэг |                 |
5. Эхийн эрхт овгийн гол шинжийг доорх өгөгдлүүдийн аль нь илэрхийлж байна вэ? (2 оноо)
- А. Хүн сүргээрээ амьдрах зорилгоор нэгдсэн бүлэг хүмүүс  
 В. Аймгийн холбоонд нэгдсэн бүлэг хүмүүс  
 С. Цэргийн ардчиллын хэлбэр  
 Д. Цусан холбоо бүхий хүмүүсийн нэгдэл  
 Е. Төр улс үүсэхийн өмнөх бүлэг хүмүүс
6. “Торгоны зам”-ыг эрхшээлдээ авсан эртний улсыг нэрлэнэ үү. (2 оноо)
- |          |             |          |          |           |
|----------|-------------|----------|----------|-----------|
| А. Хүннү | В. Тоба-Вей | С. Нирун | Д. Уйгур | Е. Сяньби |
|----------|-------------|----------|----------|-----------|
7. Монголын Нууц Товчоонд “Тэнгэрт нар сар хоёр гэрэлтэн, гэгээ болтугай хэмээн нар, сар хоёр байдаг буй за. Газарт хоёр хаан байж болох?” хэмээх үгийг хэн хэлсэн бэ? (2 оноо)
- |            |           |         |          |           |
|------------|-----------|---------|----------|-----------|
| А. Тэмүжин | В. Тоорил | С. Таян | Д. Алтан | Е. Жамуха |
|------------|-----------|---------|----------|-----------|
8. Монголын эртний улсуудаас аль нь анх оны цолыг хэрэглэх болсон бэ?
- |          |           |          |          |          |
|----------|-----------|----------|----------|----------|
| А. Хүннү | В. Сяньби | С. Нирун | Д. Түрэг | Е. Уйгур |
|----------|-----------|----------|----------|----------|
9. Монголчууд эзэнт гүрнийхээ эрхшээлд оруулсан ард түмнүүдэд ямар бодлого явуулдаг байсан бэ? (2 оноо)
- |   |                                 |
|---|---------------------------------|
| А. Хууль зүйт төрийн шудрага ёс тогтоох | В. Шашин мөргөлийг нь хүндэтгэх |
| С. Бусад үндэстнүүдийг уусгахгүй        | Д. Бүгд буруу                   |
| Е. Аль нь ч хамааралгүй                 |                                 |

10. Татарууд Охинбархагийг гэнэдүүлэн баривчилж Алтан улсад хүргүүлэн модон илжгэнд хадаж амийг нь хөнөөлгүүлсэн. Тэрбээр Хамаг Монголын хааны хэний нь хүү байсан бэ? (2 оноо)  
А. Хабул хаан В. Амбагай хаан С. Хотула хаан  
D. Гүр хаан E. Есүхэй
11. XI-XII зууны үеийн Монгол ханлиг аймгуудын нийгмийн бүтцийг харахад жирийн иргэдийг урт дурын хүмүүс, харьяат зарц, өтөгү боол, онгу боол хэмээн ангилсан байдаг. Онгу боол гэж ямар хүмүүсийг хэлдэг вэ? (2 оноо)  
А. Эзний харьяанд цаггүй, хөлсгүй ажиллагсад  
B. Боол байж байгаад эзэндээ үнэнч зүтгэж гавьяа байгуулаад чөлөөлөгдөж, онголсон хүмүүс  
C. Онгу хэмээх газраас боол бологсод  
D. Өтгөсийн үеэс үе дамжсан боол  
E. А ба В
12. Сартуул иргэн хэмээгддэг Хорезм хэзээ Монголчуудад бүрэн эзлэгдсэн бэ? (2 оноо)  
А. 1221 он В. 1223 он С. 1224 он  
D. 1222 он E. 1225 он
13. Чингис хаан “Төрийн хар хайрцаг”-ны бодлогын нууцыг чандлан, залгамжлуулахаар хэнийг итгэмжилсэн бэ? (2 оноо)  
А. Зүчи В. Цагаадай С. Өгөдэй  
D. Тулуй E. Елюй Чу-Цай
14. Тэмүжин “Хагацсан улсаа хамтатгах, бутарсан улсаа цуглуулах” хэргийг үүсгэхдээ хэнийг анх түшиглэсэн бэ? (2 оноо)  
А. Гурван мэргидийн Тогтоа Бэхи В. Найманы Таян хаан  
C. Татар аймгийн Ажэхан D. Хэрэйдийн Тоорил ван  
E. Жадараны Жамуха
15. Чингис хааны “дархалсан хүмүүс”-ийг нэрлэнэ үү. (2 оноо)  
А. Борохул, Боорчи, Мухулай, Чулуун В. Зэлмэ, Зэв, Борохул, Мухулай, Шихихутаг  
C. Зэв, Боорчи, Мухулай, Шихихутаг D. Борохул, Зэлмэ, Боорчи, Сорхон шар  
E. Шихихутаг, Мухулай, Борохул, Зэлмэ
16. Юан гүрний үед Давааны арын мужийг хэн захирдаг байсан бэ? (2 оноо)  
А. Их хаан В. Хаанаас томилсон түшмэл  
C. Жин (Жонон) ван D. Дотоод бичгийн яамны сайд  
E. Хэн ч захирдаггүй байсан
17. Төр шашныг хослон барих хоёр ёсны тухай өгүүлсэн сэтгэлгээний бүтээлийг нэрлэнэ үү. (2 оноо)  
А. Ганжуур  
B. Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх  
C. Хаадын үндэсний хураангуй Алтан товч судар оршив  
D. Эртний Монголын үндэсний их шар тууж оршив  
E. Данжуур
18. Манжийн хуулиар хутагтын шавь нарын тоо хэд хүрэхэд тусгай захиргаа байгуулж, тамга олгохоор заасан байдаг вэ? (2 оноо)  
А. 700 В. 900 С. 800 D. 1000 E. 600
19. 1449 онд Түмү цайзад болсон тулалдаанаар Мин улсын Инзүн хааныг хэн олзлон авсан бэ? (2 оноо)  
А. Галдан бошигт В. Лигдэн хаан С. Эсэн тайш  
D. Цогт тайж E. Даян хаан
20. Монгол нутагт анхны төрт улсаа байгуулсан Хүннүгийн төрийн шашин юу байсан бэ? (2 оноо)  
А. Христос шашин В. Бурханы шашин С. Бумбын шашин  
D. Лалын шашин E. Бөөгийн шашин
21. Олноо өргөгдсөн Монгол улсын талаар Хятад улс ямар байр суурьтай байсан бэ? (3 оноо)  
А. Монгол улсыг үл зөвшөөрч, өөрийн орны бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзсэн  
B. Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн  
C. Сайн хөршийн харилцаа тогтоохыг харилцан зөвшөөрсөн  
D. Тус, тусдаа бие даан оршихыг эрмэлзэж байсан  
E. Бүгд зөв
22. XIII зууны Их Монгол Улсын нийслэл Хархорум хотын хааны ордоны өмнөх мөнгөн модыг хэн урласан бэ? (2 оноо)  
А. Монгол дархан Төмөр В. Хятад дархан Жан  
C. Франц дархан Вильгельм Бушье D. Унгарын дархан Жиованни  
E. Алтан улсын дархчууд

23. “Удам угсаагаа сайн мэддэг арабуудыг эс тооцвол Монголчуудаас өөр нэг ч аймаг улс ийм заншилтай байгаагүй юм” хэмээн аль түүхч хэлсэн бэ? (2 оноо)  
 А. Рашид-ад-Дин В. Шихихутаг С. В.Я.Владимирцов  
 D. Г.Сүхбаатар E. Ш.Нацагдорж
24. Юан улсын үеийн төрийн дээд байгууллага нь Дотоод бичгийн яам байсан бөгөөд түүний харьяанд байх 6 яамыг нэрлэнэ үү. (3 оноо)  
 А. Цэргийн, Гадаад харилцаа, Ёслолын В. Нууц бичгийн, Цэргийн, Шүүх  
 С. Түшмэлийн, Сангийн, Ёслолын D. Шүүх, Цэргийн, Үйлдвэрлэхүй  
 E. С ба D
25. Манжаас 1728 онд Халхын дөрвөн аймгийн чуулганыг хаана байхыг тогтоон нутаг заажээ. Аймгуудын нэрийг олно уу. (4 оноо)  
 А. Түшээт хан 1. Биндэрьяа нуурын  
 В. Сэцэн хан 2. Цэцэрлэг уулын  
 С. Засагт хан 3. Хан уулын  
 D. Сайн ноён 4. Хэрлэн барс хотын  
 А. 1D 2A 3B 4C В. 1B 2C 3A 4D С. 1C 2D 3A 4B D. 1A 2C 3B 4D
26. Сум ард гэж хэнийг хэлэх вэ? (2 оноо)  
 А. Сүм хийд, хутагт хувилгаадын мэдэлд захирагддаг ард  
 В. Хавт Хасар, Отчигины харьяат ард  
 С. Харьяалагдах аймаг, хошууны ноёд, язгууртануудад алба залгуулагчид  
 D. Манж хааны ба төрийн алба залгуулдаг ард  
 E. Манжийн хааны төмөр сүргийг хариулагчид
27. Монгол Оросын хилийн заагийг 1727 онд тогтоов. Ямар гэрээгээр зохицуулсан бэ? (2 оноо)  
 А. Хиагтын гэрээ В. Буурын гэрээ С. Гурван улсын гэрээ  
 D. Нэрчүгийн гэрээ E. Манжийн хааны зарлигаар
28. 1918 оны байдлаар хамгийн олон хүн амтай байсан аймгийг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Засагт хан В. Сайн ноён хан С. Цэцэн хан  
 D. Түшээт хан E. Их шавь
29. Богд хааны зарлигаар бичигдсэн “Зарлигаар тогтоосон Монгол улсын шаштир” хэмээх он дарааллын бичгийг хэдийд зохиосон бэ? (2 оноо)  
 А. 1912 он В. 1923 он С. 1921 он D. 1916 он E. 1918 он
30. 1946 оноос ямар бичгийг төрийн албан ёсны бичиг болгосон бэ? (2 оноо)  
 А. Латин бичиг В. Монгол бичиг С. Кирилл бичиг D. Вагиндрын үсэг
31. Японоос бусад дорно дахины орнуудыг Монгол гүрний мэдэлд оруулсан их хааныг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Мөнх В. Хубилай С. Гүюг D. Өлзийт E. Хүлэг
32. Манжийн хаан 1907 онд Монгол нутгийг хагалбарлан тариа тарих зарлиг буулгаснаас хойш дөрвөн жилийн дотор Ар Монголд байгаа хятад иргэдийн тоо 100 мянгад хүрчээ. Энэ нь юунд чиглэгдэж байсан бэ? (2 оноо)  
 А. Монголын эдийн засгийг дэмжих В. Газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх  
 С. Монголчуудыг хятадчилах D. Монголчуудыг тариалангийн ажилд сургах
33. Түүхэн сэдэвтэй бичигдсэн зохиол бүтээлүүдийн нэг нь “Хөх судар” түүхэн роман билээ. Энэ бүтээлийн зохиогч нь хэн бэ? (2 оноо)  
 А. Занабазар В. Д.Равжаа С. В.Инжинаш  
 D. Намхайжамц E. Туульч Парчин
34. Улс төрийн бутралын үеийн баруун, зүүн Монгол, Дөрвөн Ойрад дотроо хэд хэдэн түмэнгээс бүрэлдэх болжээ. Дараах өгөгдлүүдийн аль нь зөв бэ? (2 оноо)  
 А. Зүүн Монгол, халх, цахар урианхай гэсэн 3 түмнээс бүрдэнэ  
 В. Баруун гарын гурван түмэн ордос, түмэд, юншээбүгээс бүрдэнэ  
 С. Дөрвөн ойрад нь торгууд, дөрвөд, чорос, хошуудаас бүрдэнэ  
 D. Бүгд зөв  
 E. Бүгд хамааралгүй
35. 1921 оны XI сарын 1-ний АЗГ-ын тогтоолоор Богд хаан, Засгийн Газрын эрх хэмжээ, тэдний хоорондын харилцааны зарчмыг тодорхойлжээ. Уг баримт бичгийг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Их шавийн дүрэм В. Засаг төрөөс ойрын цагт гүйцэтгэх бодлогууд  
 С. Богд хааны эрхийг хязгаарлах дүрэм D. Тангарагийн гэрээ  
 E. Их шавийн хэрэглээг хязгаарлах дүрэм
36. Нийслэл хүрээнд Монгол Улсын банкыг хэзээ нээсэн бэ? (2 оноо)  
 А. 1912 он В. 1914 он С. 1915 он D. 1917 он E. 1919 он

37. Зүүн Хүрээний нууц бүлгэмийн гишүүдийг нэрлэнэ үү. (2 оноо)  
А. Д.Бодоо, Ө.Дэндэв, М.Дугаржав, Д.Сүхбаатар  
В. Д.Сүхбаатар, Д.Лосол, С.Жамъян, Д.Догсом  
С. Ө.Дэндэв, С.Данзан, Д.Догсом, М.Дугаржав  
D. Д.Бодоо, С.Данзан, Д.Чагдаржав, Д.Сүхбаатар  
E. Д.Бодоо, С.Данзан, М.Дугаржав, Д.Сүхбаатар
38. Шинэ тутам байгуулагдсан Ардын Засгийн Газраас төр засгийн бүтэц, үйл ажиллагааг төлөвшүүлэхээр хийсэн ажлыг нэрлэнэ үү. (2 оноо)  
А. Хууль цаазыг шинэчлэх, түр цагийн хурал байгуулах  
В. Орин нутгийн засагт захиргааг өөрчилж, хамжлагат ёсыг халах  
С. Богд хааны эрх хэмжээг тодорхойлох  
D. Бүгд хамааралгүй  
E. Бүгд зөв
39. БНМАУ-д анх хэдэн оноос үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэх болсон бэ? (2 оноо)  
А. 1921он В. 1925 он С. 1924 он  
D. 1926 он E. 1927 он
40. Нийслэл хүрээг чөлөөлсний дараа Ардын засгийн газраас эх орноо цагаантнаас бүрэн чөлөөлөх явдалд онцгой анхаарч Сагсайн хүрээ, Бага харгай, Толбо нуур, Саруул гүний хүрээ, Улаангомд хэний удирдсан цагаантны хүчийг бут цохисон бэ? (3 оноо)  
А. Барон Унгерн, Сундуй гүн, Бакич В. Сухарев, Найдан ван, Кайгородов  
С. Казанцев, Барон Унгерн, Сухарев D. Кайгородов, Бакич, Казанцев  
E. Кайгородов, Казанцев, Резухин
41. “Улсын дээд эрхийг Улсын их хурал барина. УИХ-ын чөлөөт цагт Улсын Бага хурал төрийн хэргийг эрхэлнэ” хэмээн ямар баримт бичигт заасан бэ? (2 оноо)  
А. Засгийн газрын дүрэм В. Тангарагийн гэрээ  
С. Үндсэн хууль D. Орон нутгийн засаг захиргааг шинэчлэх дүрэм  
E. Бүгд зөв
42. МАХН-ын III их хурал дээр “Монгол Ардын намын эцсийн зорилго нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал, хөрөнгөтний шатыг алгасан энэ зорилгод хүрэх ёстой” хэмээн илтгэл тавьсан хүнийг нэрлэнэ үү. (2 оноо)  
А. С.Данзан В. Ж.Цэвээн С. Э.Ринчино  
D. Б.Цэрэндорж E. А.Амар
43. 1929-1932 оны хооронд “Хөрөнгө хураах комисс” байгуулж, орон даяар феодал агсадын хөрөнгө хураах ажиллагаа орон даяар эхэлжээ. Уг комисс хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байсан бэ? (2 оноо)  
А. 4 В. 6 С. 8 D. 12 E. 14
44. Коминтерныхан яагаад Монголын дотоод хэрэгт идэвхтэй оролцох болсон бэ? (2 оноо)  
А. Монголд туслахын тулд  
В. Монголын удирдагчдын хүсэлтийн дагуу  
С. Коминтерн туршилт хийж, нөлөөндөө байлгахын тулд  
D. Коминтерны төлөөлөгчдийн боловсрол дорой байснаас
45. Зүүнтний үед хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд хамаарахгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)  
А. Малын тоо толгой нэмэгдсэн  
В. Хүмүүсийн санаа сэтгэл алдарч эхэлсэн  
С. Ядуудаа дулдуйдан бэлэнчлэх сэтгэлгээг ард түмэнд бий болгосон  
D. Төр засгийн бодлогыг эсэргүүцэн нүүх, дүрвэх, бослого хөдөлгөөн гаргасан
46. Сангийн яамны дэргэд мал эмнэлгийн хэлтэсийг хэдэн онд байгуулсан бэ? (2 оноо)  
А. 1921он В. 1922 он С. 1923 он  
D. 1924 он E. 1925 он
47. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу. (2 оноо)  
А. БНХАУ 1. 1936 оны 3-р сарын 12  
В. ЗСБНХУ 2. 1946 оны 1-р сарын 5  
С. НҮБ 3. 1961оны 10-р сарын 27  
А. А2 В1 С3 В. А1 В2 С3 С. А3 В1 С2 D. А3 В2 С1
48. Соёл гэгээрэл, шинжлэх ухааны хөгжилт (1921-1924)-нд хамаарах дараах ойлголтоос ташааг нь олно уу. (2 оноо)  
А. 1921.11.02-нд Нийслэл хүрээнд 40 сурагчтай бага сургууль байгуулав  
В. 1922 оны 10-р сард Нийслэл Хүрээнд анхны европ эмнэлэг байгуулагдав  
С. 1924 онд АЗГ-ын тогтоолоор судар бичгийн хүрээлэн байгуулагдсан  
D.1922-1923 оноос Агe/; ЗХУ-ын шинжилгээний ангиуд Монголд ажиллах болсон  
(Ч.Эндрьюс, П.К.Козлов)

49. Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд энгийн худалдаа хөгжүүлэх талаар доорх зүйлүүдээс алийг нь хэрэгжүүлсэн бэ? (2 оноо)  
 А. 1932 онд нийгмийн гарал, хөрөнгө чинээний байдлыг харгалзахгүйгээр хувийн худалдаа хийх; худалдааны пүүс; нөхөрлөл байгуулахыг зөвшөөрсөн  
 В. Бөөний болон жижиглэнгийн үнээр бараа авах, банкнаас зээл авах, эрх олгосон  
 С. Хувийн худалдаачдад улсын бүх экспорт, импорт хийх эрх өгсөн  
 D. Бүгд зөв  
 E. А ба В
50. Гүюг хааны явуулсан бодлогын үндсэн чиглэлийг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Хууль дүрмийг чангатгасан  
 В. Хүн амын тооллого явуулж; албан татварыг журамласан  
 С. Алтан улсыг бүрэн эзлэх, Өмнөд Сүн улстай байлдах бодлого явуулсан  
 D. А ба С  
 E. Бүгд зөв
51. Дараах зүйлийн аль нь Шинэ засгийн бодлогод хамааралгүй вэ? (2 оноо)  
 А. Монгол нутагт цэргээр тариа тариулах  
 В. Банк нээж; мөнгөний бодлогыг зохицуулах  
 С. Хятад худалдаачдын гадагш гаргах бараанд хязгаар тавих  
 D. Бүгд зөв
52. Ар Монгол дахь Манж Чин улсын дээд эрх барих байгууллага “Улиастайн жанжны газар”-ын жанжины хариуцах ажлыг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Хязгаар дахинд холбогдсон чухал хэргийг шийтгэх  
 В. Дөрвөн аймгийн цэргийн бэлтгэл хэргийг захирах  
 С. Өөртөө харуулыг цагдах  
 D. Оргодол болон хэрэгтнийг байцаан барих  
 E. Бүгд зөв
53. Зүүнтний үеийн “Жасын компани”-ий гол агуулга нь юу байсан бэ? (2 оноо)  
 А. Жасыг дэмжин хөгжүүлэх  
 В. Сүм; хийдийн малыг хамтрал болон энгийн ардуудад гэрээгээр шилжүүлэх  
 С. Сүм, хийдийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх  
 D. Жас; жавын үйл ажиллагааг энгийн ардуудад ойлгуулах  
 E. Бүгд хамааралгүй
54. Монгол Улсад хэзээ засаг захиргааны шинэчлэл хийж, хошууг өөрчлөн 13 аймгийг байгуулсан бэ? (2 оноо)  
 А. 1924 он В. 1931 он С. 1938 он D. 1941 он E. 1945 он
55. Намын хэддүгээр бүгд хурал дээр Х.Чойбалсанг тахин шүтэж байсан болон хууль ёсыг ноцтой зөрчиж; үй олон хүнийг хэлмэгдүүлсэн явдлыг анх удаа албан ёсоор хэлэлцэж шүүмжилсэн бэ? (2 оноо)  
 А. 1955 оны III бүгд хурал В. 1956 оны IV бүгд хурал С. 1957 оны VIII бүгд хурал  
 D. 1959 оны XIII бүгд хурал E. 1961 оны II бүгд хурал
56. Гандантэгчинлэн хийдийн үйл ажиллагааг хэдэн онд сэргээсэн бэ? (2 оноо)  
 А. 1944 он В. 1945 он С. 1946 он D. 1947 он E. 1948 он
57. 1945 оны чөлөөлөх дайнд оролцож баатарлаг гавъяа байгуулан БНМАУ-ын баатар цолоор шагнуулсан эрэлхэг дайчдыг нэрлэнэ үү. (2 оноо)  
 А. Л.Дандар, Ц.Олзвой, П.Чогдон В. Л.Аюуш, Л.Дандар, П.Чогдон  
 С. Л.Аюуш, Д.Данзанваанчиг D. Ц.Олзвой, П.Чогдон  
 E. Бүгд хамааралгүй
58. Манай улсад засгийн эрх мэдэл хэний гарт байдаг вэ? (2 оноо)  
 А. Ерөнхийлөгчийн В. УИХ С. Засгийн газрын  
 D. Ард түмний E. Улс төрийн намын

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

- 2.1. Манжийн үеийн Ар Монголын ноёдын зэрэг дэвд тохирох цалин пүнлүүг харгалзуулна уу. (5 оноо)  
 А. Жун вангууд 1. 800 лан, торго 13 хуй  
 В. Чин вангууд 2. 300 лан; торго 9 хуй  
 С. Бэйс 3. 1200 лан, торго 15 хуй  
 D. Бэйл 4. 2000 лан; торго 25 хуй  
 E. Улсын түшээ гүн 5. 500 лан, торго 10 хуй

- 2.2. Монголын хууль цаазны түүхэнд холбогдох хуулиудыг харгалзах онтой нь тааруулна уу. (5 оноо)
- |  |            |
|--|------------|
| А. Дөчин дөрвөн хоёрын их цааз                                   | 1. 1918 он |
| В. Халх журам  | 2. 1789 он |
| С. Юан төрийн хууль цаазын бичиг                                 | 3. 1709 он |
| Д. Гадаад Монголын төрийг засаг явдлын яамны хууль зүйлийн бичиг | 4. 1320 он |
| Е. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг          | 5. 1640 он |



## 2008 оны Монгол улсын түүхийн хичээлийн даалгаврын түлхүүр

№	Хувилбар D	Хувилбар F	Хувилбар G
1	A	A	E
2	C	A	B
3	C	D	D
4	C	B	E
5	A	A	D
6	D	D	A
7	D	C	C
8	D	C	C
9	C	A	B
10	E	B	A
11	E	D	B
12	B	D	C
13	B	D	D
14	B	C	D
15	B	C	D
16	D	B	C
17	C	D	B
18	D	D	A
19	A	C	C
20	D	E	E
21	E	C	A
22	E	C	C
23	A	D	A
24	B	E	E
25	D	A	C
26	E	D	D
27	B	B	B
28	E	C	B
29	D	C	E
30	C	A	C
31	C	B	B
32	E	B	C
33	B	B	C
34	D	C	D
35	D	E	D
36	D	D	C
37	C	D	C
38	A	C	B
39	D	E	B
40	C	D	D
41	D	E	C
42	C	A	C
43	B	B	C
44	C	D	C
45	A	C	A
46	B	C	C
47	C	B	A
48	B	D	C

№	Хувилбар D	Хувилбар F	Хувилбар G
49	A	A	E
50	C	D	A
51	D	D	C
52	B	D	E
53	C	D	B
54	D	A	B
55	A	D	B
56	C	B	A
57	B	C	C
58	D	C	D

Хоёрдугаар хэсэг						
	Хувилбар D		Хувилбар F		Хувилбар G	
	2.1	2.2	2.1	2.2	2.1	2.2
a	3	4	4	5	3	5
b	2	1	1	3	4	3
c	1	5	2	4	5	4
d	4	3	3	2	1	2
e		2	5	1	2	1